БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН III УЛИРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. **Багш нарын бага хурал боллоо.**

**“ӨЧИГДРИЙГ ДҮГНЭЖ, ӨНӨӨДРИЙГ БҮТЭЭЖ, МАРГААШИЙГ ЭХЛҮҮЛЦГЭЭЕ”** уриатай Сүхбаатар аймгийн боловсролын салбарын багш, удирдах ажилтнуудын “БАГА ХУРАЛ”-ыг 2024.08.27-28 өдрүүдэд зохион байгууллаа. Бага хуралд нийт 450 багш, удирдах ажилтан, зочид төлөөлөгчид оролцлоо. Багш нарын бага хурлыг

- ☑ Сургалтын чанар–асуудал, шийдэл
- ☑ Суралцагчийн хөгжил хамгаалал
- ☑ Боловсролын салбарын хүний нөөц
- ☑ Боловсролын менежмент гэсэн 4 чиглэлийн салбар хуралдаанаар зохион

байгуулж боловсролын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл, арга замын талаар хэлэлцлээ. Салбар хуралдаан тус бүр 100 оролцогч, 2 чиглүүлэгчтэй зохион байгуулсан бөгөөд ирэх хичээлийн жилд анхаарах асуудал болон цаашид хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулахад үнэтэй санал хүсэлтийг багш, удирдах ажилтнууд дэвшүүлж 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой болголоо.







Багш нарын бага хурлын нэгдсэн хуралдаанаар салбар хуралдаанаас гарсан асуудлуудыг нэгтгэн дүгнэж 2023-2024 оны хичээлийн жилийн ололт амжилт, боловсролын салбарын бодлого төлөвлөлтийн үр дүн, асуудал шийдэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, шинэ хичээлийн жилийн зорилго, зорилт, онцлогийг хэлэлцлээ.

Хурлын үйл ажиллагаанд Аймгийн Засаг дарга М.Идэрбат оролцож боловсролын салбарт хийсэн хөрөнгө оруулалтын талаар илтгэл тавьж, өнгөрсөн хичээлийн жилд амжилттай ажилласан сургууль, багш нарыг Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшууллаа.



Мөн энэ үеэр МУБИС-ийн эрдэмтэн, докторуудтай хамтран шинэ зууны боловсролын чиг хандлага, үзэл баримтлал бүхий онол, арга зүйн сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтыг МУБИС-ийн академич Б.Жадамба, доктор, дэд профессор О.Алтангоо, доктор Т.Ганбаатар нар удирдан явуулсан бөгөөд нийт 400 багш, удирдах ажилтан оролцож шинэ зууны боловсролын чиг хандлага, үзэл баримтлал онол арга зүйд суралцсанаараа онцлог байлаа.

## 2. “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.

“Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье” уриатай “ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” арга хэмжээг 2024.09.12-22 өдрүүдэд салбарын хэмжээнд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Үйл ажиллагааны хүрээнд бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, номд дурлуулах, номтой нөхөрлүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх , үндэсний бичиг соёлоороо бахархах, өв соёлоо дээдлэн дэлгэрүүлэх олон үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

- **“Номын хишиг- Эрдмийн түшиг”** уншлага, хэлэлцүүлгийг сургууль бүр зохион байгууллаа.





- Үндэсний бичиг үсгийг сурталчилан таниулах зорилгоор **“Үндэсний бичиг-Бидний бахархал”** контент бэлтгэн нийтийн хүртээл болгохоос гадна уран бичвэр, хичээнгүй бичвэр, уншсан номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргалаа.







3. **“Цэгээр наадъя-Зурлага бичвэрээр хүүхдийн цогц хөгжлийг дэмжих нь” арга зүйн цахим сургалт зохион байгууллаа.**

“Цэгээр наадъя-Зурлага бичвэрээр хүүхдийн цогц хөгжлийг дэмжих нь” арга зүйн цахим сургалт Сүхбаатар аймгийн сургуулийн өмнөх боловсролын 80 гаруй багш нар хамрагдлаа. Сургалт 2024.09.21-22 өдрүүдэд өглөөний анги, өдрийн анги гэсэн 2 бүлгээр “Цэгээр наадъя” арга технологийн үүсэл, хөгжил, цэг, зураасны тухай онол, Зурлага бичих болон заах аргачлал, Зурлага ашиглан зураг зурах 5 аргачлал, Хүүхдийн хөгжлийг дэмжих 5 алхам буюу “5 хурууны арга” Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах нь агуулгын хүрээнд зохион байгуулагдаж багш нар хүүхдийн бүтээлч үйлийг дэмжих арга зүйд суралцаж ур чадвараа хөгжүүллээ.

4. **“Бага насны хүүхдийн цогц хөгжил”-ийн сургалт боллоо.**

“Бага насны хүүхдийн цогц хөгжил”/2023-2027он/ аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар мэдээлэл олгох, арга зүйгээр хангах зорилгоор Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын цэцэрлэгийн багш, ажилтан албан хаагчид, хүүхэд хамгааллын баг, эцэг эх асран хамгаалагчдад зориулсан сургалтыг аймгийн ХГБХХГ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад сургуулийн өмнөх боловсролын багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл нийт 200 гаруй хүн хамрагдлаа.





5. **Элсэлтийн шалгалтад 1500 гаруй шалгуулагч хамрагдлаа.**

2024 оны элсэлтийн шалгалтад давхардсан тоогоор 1604 шалгуулагч бүртгүүлсэнээс ирц 1500 буюу 94% нь шалгалтандаа оролцлоо. Элсэлтийн шалгалтийг 2024.07.04-07 өдрүүдэд, 2024.08.17-ны өдөр Монгол хэл бичгийн дахин шалгалтыг  орон нутгийн түвшинд амжилттай зохион байгууллаа.

6. **“МУ-ын Байгалийн ухааны боловсролын чадавх, үр өгөөжийг нэмэгдүүлэх” төслийн сургалт боллоо.**

“МУ-ын Байгалийн ухааны боловсролын чадавх, үр өгөөжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд зохион бүтээсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг Сүхбаатар аймгийн ЕБС-уудад түгээн дэлгэрүүлэх сургалт, байгалийн ухааны туршилтат өдөрлөг 2024 оны 09-р сарын 16-ны өдөр ерөнхий болдовсролын 3-р сургууль дээр зохион байгуулагдлаа. Өдөрлөгөөр МУБИС-ийн багш, оюутнууд, төслийн мэргэжилтнүүд хамтран бага боловсролын 30 багш, физикийн 10 багш, ЕБС-ийн 300 сурагчид сургалт амжилттай зохион байгуулав. Сургалтын үр дүнд багш нар байгалийн ухааны хичээлээр ахуйн орчинд гарын доорх материалаар туршилтыг хэрхэн хийх арга зүй эзэмшив.





7. **“Жагсаалч анги” уралдааныг хичээлийн жилийн туршид 2 үе шаттай зохион байгуулж байна.**

2024 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр бага, дунд ангийн сурагчдын хөдөлгөөний эвсэл, хурд тааруу үнэлэгдсэн учир энэ хичээлийн жилд боловсролын газраас сурагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, дасгал хөдөлгөөнийг өдөр тутам хийж





хэвшүүлэх зорилгоор “Жагсаалч анги” аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд 2-6-р ангийн сурагчид биеийн тамирын хичээлээр жагсаалын хувиргалт, 16,32 тоот дасгалыг сурч эзэмшин сургууль болон ангийн цахим хаягаар дамжуулан олон нийтэд түгээж сурталчилж байна.

8. **Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн Хамран сургах тойрог тогтоолоо.**

Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д "Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно" гэсэн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Боловсролын газрын даргын тушаалаар хамран сургах тойрог тогтоолоо.

Тогтоосон хамран сургах тойргийн дагуу манай аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах 2-5 настай аймгийн хэмжээний 6000 гаруй хүүхдээс 5400 гаруй суралцагчийг, 1-р ангид элсэн суралцах 6 настай 1482 суралцагчаас 1422 суралцагчийг урьдчилсан байдлаар хамруулсан байна. Хамран сургах тойргийн дагуу элсэлт бүртгэлийг хийж байгаа эсэхэд Боловсролын газраас хяналт хийж ажиллаа.





9. **Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, мониторинг хийгдлээ.**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж үнэлгээг зохион байгуул
2024-2025 оны хичээлийн жилд СББҮ-нд 16 сургуулийн 45 бүлгийн 1434 суралцагч хамрагдлаа. СББҮ-ний явцад Боловсролын яамны чанарын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Ганцэцэг 9сарын 17-19-ний өдрүүдэд Баруун-Урт сумын 1,2,3-р сургууль дээр:

- СББ-ыг үнэлэх үнэлгээний ерөнхий зохион байгуулалт сургуулийн түвшинд хэрхэн явагдаж байгаа талаар мэдээлэл авах, үйл ажиллагаатай танилцах
- Сургууль дээрх үнэлгээний багийн тушаал шийдвэр, багийн гишүүдийн оролцож буй байдал
- Үнэлгээ зохион байгуулж буй анги танхимын зохион байгуулалт, шаардлага хангаж буй байдал

- ➢ Сургууль, цэцэрлэгийн хамтын үйл ажиллагаа, эргэх холбоо
- ➢ Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй явц, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэж буй арга зам, зөвлөн туслах багийн гишүүний зүгээс өгсөн заавар, зөвлөмж
- ➢ Багш нарын үнэлгээ хийж буй арга барил, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэж буй байдал /үнэлгээний даалгаврыг зааврын дагуу асуух, чиглүүлэх, хүүхдээр гүйцэтгүүлэх, хүүхдийн гүйцэтгэлийг тэмдэглэх, оноожуулж буй байдал/
- ➢ Хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх хүрээнд “Хүүхдийн хөгжлийн үнэлгээ”-нд хамрагдах хяналтын суралцагчийг сонгох, үнэлгээг зохион байгуулах, мэдээллийг маягтад бүртгэх, системд шивж оруулах
- ➢ Хүүхдийн хөгжлийн үнэлгээний даалгавар болон хэрэглэгдэхүүний нийцэл, сайжруулах санал зөвлөмж өгсөн эсэх
- ➢ Даалгавар гүйцэтгэхэд ашиглаж буй хэрэглэгдэхүүн чанарын шаардлага хангаж буй эсэх гэсэн чиглэлийн дагуу хянаж, фокус ярилцлага хийж ажиллалаа.

Мониторингийн хяналтанд 3 сургуулийн сургалтын менежер, багш , сурагч , эцэг эхийн төлөөлөл , цэцэрлэгийн арга зүйч , бүлгийн багш гэсэн нийт 112 хүн хамрагдлаа.

Хяналтаар ажилласан үр дүнг сургуулийн менежер болон боловсролын газрын даргад танилцуулж “Хангалттай сайн” гэсэн үнэлгээгээр үнэлэгдлээ. Цаг үеийн мэдээллийг Боловсролын газрын удирлагын групп болон нээлттэй https://www.facebook.com/ цахим хуудсаар мэдээллээ.





СББҮ-ний үр дүнг https://sub.eec.mn/ талбарт хугацаанд нь шивж орууллаа.



10. **Сургуулийн менежментийг сайжруулах арга зүйг дэмжих сургалт боллоо.**

Арга зүйг дэмжих сургалтад 10 сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан нийт 31 удирдлага оролцож өөрсдийн сургуулийн өнгөрсөн жилийн тайлан, ирэх хичээлийн жилийн төлөвлөлт, зураглал дээрээ 7 ажлын хуудасны дагуу ажиллаж тайланг хэрхэн үр дүнтэй бичиж, ирэх хичээлийн жилийн төлөвлөлтдөө тусгах, хичээлийн жилийн зураглал төлөвлөгөөний уялдаа холбоо, төлөвлөлтийг зорилго зорилтоо дэмжих, хүсч буй хүүхдийн дүр төрхөд нийцүүлэн сургалт, хүмүүжил, эрүүл мэнд гэсэн алтан гурвалжинг барьж төлөвлөх зэрэг суурь ойлголтуудаа бататган хамтран гүйцэтгэлээ.

Үр дүн: Сургууль бүр зураглал төлөвлөгөөгөө сайжруулж энэ хичээлийн жилийн төлөвлөлтөө сурагч, багш, ажилтан удирдлагуудын саналыг тусгаж оруулллаа.





11. **Зөвлөн туслах үйл ажиллагаа**

Боловсролын газрын Зөвлөн туслах баг Дарьганга, Онгон, Наран сумын сургууль, цэцэрлэг дээр 5 өдөр ажиллаж хүний нөөцийн бүрдэлт, архив бичиг хэрэг, сургалт үйл ажиллагааны ажиглалт- дүгнэлт-хэлэлцүүлэг, байгууллагын менежментийн зураглал, төлөвлөлт, багш ажилтан албан хаагчдын уулзалт, сурагчдын уулзалт зэргийг зохион байгуулж цаашид анхаарах, сайжруулах ажлын чиглэл өглөө.

12. **Eduten хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллаж байна.**

2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангаж 8 сард орон нутгийн хэмжээнд 2,3-р ангид хичээл заах 95 багшид хосолсон сургалтын аргаар “ Eduten хичээлийн арга зүй” сургалтыг зохион байгуулж , арга зүйгээр хангаж ажиллалаа. Мэдээллээ БЕГ-т хүргүүлж, түгээн дэлгэрүүллээ.




2024-2025 оны хичээлийн жил эхэлсэн энэ өдрүүдэд Финландын Туркугийн их сургуулийн Эдүтэн хөтөлбөрийг санаачлагч эрдэмтэн, багш нар Монголд ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийж ажиллахад жилийн эхний 1 сар буюу 4 долоо хоногийн явц, үр дүнгийн мэдээллээр манай аймаг улсдаа үйл ажиллагаагаараа 2 дугаарт эрэмбэлэгдсэн бахдам амжилт үзүүллээ.

Энэхүү үйл ажиллагааг чиглүүлж анги бүр дээр дэмжлэгийн баг байгуулахаас гадна боловсролын газрын мэргэжилтэн, сургалтын менежерүүд багш нар аа чиглүүлэ , 7 хоног бүр ахиц амжилтаа дүгнэн ажиллаж байна**.**




Тайлан нэгтгэсэн:
Боловсролын газрын ахлах мэргэжилтэн Б.Алдармаа